



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Ж.Золзаяатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн гүйцэтгэх захирал Ж.Золзаяад хавсралтад заасны дагуу урамшуулалт олгосугай.

3.Ж.Золзаяад олгох урамшууллыг холбогдох зардлаас гаргахыг “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын Нягтлан бодогч Д.Цэрэндолгорт зөвшөөрсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Төрийн ёмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын 1-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК" ТӨРИЙН ёмчийт ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД
2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/Д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг	Цэвэр ашигийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал	Урамшуулал тооцох цэвэр ашиг	Урамшуулал тооцох цэвэр ашиг	Олгох урамшууллын хэмжээ
1	"Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ	Ж.Золзаяа	-	82,326,157.06	-	82,326,157.06	6,646,523.14 (зургаан сая, зургаан зуун дөчин таван зуун хорин гурван төгрөг арван дөрвөн мөнө)